

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

"Дархан үйлдвэрлэл технологийн парк" ОНӨААТҮГ-ын 2025 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайла

Аудитын код: ДАА-2025/6/НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: www.Shinjlenmagadlahui .ezsh.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас: 70373089, 99023682 Цахим хаяг: Munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас: 99036806 Цахим хаяг: Batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 99377479 Цахим хаяг: Battsetsegs@audit.gov.mn Аудит гүйцэтгэсэн: Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит ХХК Утас: 99197346, 88114867 Цахим хаяг: Shinjlenmagadlahui.audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.25 № 133

танай _____-ны № _____-т

“ДАРХАН ҮЙЛДВЭР ТЕХНОЛОГИЙН ПАРК”
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дархан-Уул аймгийн “Дархан үйлдвэр технологийн парк” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

“Дархан үйлдвэр технологийн парк” ОНӨААТҮГ нь тайлант онд 34.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 22.0 мянган төгрөгийн зардал гарган 306.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий

4526050242

чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулах болно.

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

СТ-1А

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	19,191.78	31,511.78
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	34,320.00	0.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	53,511.78	31,511.78
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	284,418.60	0.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	284,418.60	0.00
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	337,930.38	31,511.78
2.3.1	Өмч: -төрийн	10,528,740.00	10,528,740.00
2.3.2	-хувийн		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,785,092.06	2,785,092.06
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(12,975,901.68)	(13,282,320.28)
2.3.11	Эздний өмчийн дүн	337,930.38	31,511.78
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	337,930.38	31,511.78

СТ-2А

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого(цэвэр)	5,000,000.00	0.00
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг (алдагдал)	5,000,000.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	5,508,140.32	284,418.60
11	Санхүүгийн зардал	23,300.00	22,000.00
12	Бусад зардал	0.00	-

18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(531,440.32)	(306,418.60)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(531,440.32)	(306,418.60)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(531,440.32)	(306,418.60)

СТ-3А

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийг дүн
1	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	10,528,700.00	2,785,092.06	(12,444,461.36)	869,370.70
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	10,528,700.00	2,785,092.06	(12,444,461.36)	869,370.70
4	Тайланг үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(531,440.32)	(531,440.32)
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
9	2025 оны 01 -р сарын 01 -ний үлдэгдэл	10,528,740.00	2,785,092.06	(12,975,901.68)	337,930.38
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	10,528,740.00	2,785,092.06	(12,975,901.68)	337,930.38
12	Тайланг үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(306,418.60)	(306,418.60)

13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
14	Өмчд гарсан өөрчлөлт	-	-	-	-
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
17	2025 оны 12 -р сары 31-ний үлдэгдэл	10,528,740.00	2,785,092.06	(13,282,320.28)	31,511.78

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-4А

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,000,000.00	34,320.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	5,000,000.00	34,320.00
	Бусад мөнгөн орлого	-	-
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,103,164.00	22,000.00
	Ажиллагчдад төлсөн	3,465,644.00	0.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,025,760.00	0.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	0.00	-
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	0.00	-
	Татварын байгууллагад төлсөн	348,460.00	0.00
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	263,300.00	22,000.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(103,164.00)	12,320.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(103,164.00)	12,320.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	122,355.78	19,191.78
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	19,191.78	31,511.78

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/Төгрөг/

№	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	2025 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Нийт орлого	5,000,000.00	0.00	0.00	-	100.0
	Үүнээс: Цэвэр борлуулалт	5,000,000.00	0.00	0.00	-	100.0
2	Нийт зардал	5,531,440.32	0.00	(306,418.60)	-	100.0
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	5,531,440.32	0.00	(306,418.60)	-	100.0
3	Цэвэр ашиг, алдагдал	(531,440.32)	0.00	(306,418.60)	-	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлагналтай холбоотой алдаа зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.